



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН НЭГДСЭН САНГААС ОЛГОХ
1,118.9 САЯ ТӨГРӨГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ ДУТУУ ОЛГОСОН БАЙНА

ДОРНОД АЙМГИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДОА-2024/01/НА-СТА-ТЕЗ

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
мэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuub@audit.gov.mn
Аудитор Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар 2
 Дүрслэлийн товъёог 2
 Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл 3

БҮЛЭГ 1. ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ.

1.1.Аймгийн төсвийн орлогыг 24,538.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөж баталсан байна 4
 1.2.Аймгийн татварын нийт орлого 7.7 хувиар буюу 3,723.0 сая төгрөгөөр давж биелсэн ч зарим нэр төрлийн орлого тасарсан байна.....4

БҮЛЭГ 2. ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ.

2.1. Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас нэмэгдүүлэн төлөвлөсөн байна. 6
 2.2. Төсвийн нийт зарлага 77,330.5 сая төгрөг байна..... 7
 2.3. Дорнод аймгийн 2023 оны төсөвт 3 удаа өөрчлөлт хийсэн байна..... 8
 2.4.Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэлт санхүүжилтийн дансны нийт зардал 6,430.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.....8

БҮЛЭГ 3. ТЕЗ-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН ЗОРИЛТОТ ТҮВШИН.

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 87.2 хувийн гүйцэтгэлтэй байна. 9

БҮЛЭГ 34. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ.

4.1.Төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 86.8 хувийн хэрэгжилттэй байна. 10

ДҮГНЭЛТ: 10
 Холбогдох байгууллагын санал: 11
 ҮАГ-т хүргүүлсэн санал: 11
 ЗӨВЛӨМЖ: 12
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР 13-14

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ДОА	Дорнод аймаг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НА	Нийцлийн аудит
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЯ	Сангийн яам
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁОГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төсвийн орлогын төлөвлөлт	5
Хүснэгт 2	Төсвийн орлогын гүйцэтгэл	6
Хүснэгт 3	Зардлыг суурь хязгаартай харьцуулсан харьцуулалт	6
Хүснэгт 4	Зардлын төлөвлөлт, гүйцэтгэл	7
Хүснэгт 5	Төсөл, арга хэмжээнд орсон өөрчлөлт	8
Хүснэгт 6	Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл	9

	<p>АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ</p>
<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дорнод аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэлд аудит хийв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Орон нутгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, түүний төсвийн зарцуулалтын үр дүн үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Дорнод аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл • Дорнод аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл • ТЕЗ-ийн төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, түүний төсвийн зарцуулалтын үр дүн • Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны жилийн төсөв баталсан тогтоол болон тайлант онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээг хамрууллаа.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 200, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилтын хүрээнд хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглан гүйцэтгэх, аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Одхүү, Б.Оюунхэрлэн нар хийж гүйцэтгэлээ.</p> <p>Аудитын талбарын ажлыг 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлж, тайланг УАГ-ын Санхүү-нийцлийн аудитын газар болон аймгийн ИТХ, ТЕЗ-д 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүллээ.</p>

БҮЛЭГ 1. ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

1.1. Аймгийн төсвийн орлогыг 24,538.9 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна.

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 24,538.9 сая төгрөг буюу 70.8 хувиар нэмэгдүүлэн батлуулсан байна.

Хүснэгт 1: Төсвийн орлогын төлөвлөлт.

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	Сангийн яамны хянасан төсөв	2023 оны батлагдсан төсөв	Сангийн яамнаас хянасан зөрүү
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО		34,680.9	59,219.8	24,538.9
1	Татварын орлого	31,110.1	48,743.6	17,633.5
1.1	Орлогын албан татвар	23,600.0	34,209.9	10,609.9
1.2	Хөрөнгийн албан татвар	1,953.1	3,944.6	1,991.5
1.3	Бусад татвар (Төлбөр, хураамж)	5,557.0	10,589.1	5,032.1
2	Татварын бус орлого	3,570.8	10,476.2	6,905.4
2.1	Нийтлэг татварын бус орлого	3,570.8	5,007.9	1,437.1
2.2	Хөрөнгийн орлого	0.0	135.5	135.5
2.3	Тусламжийн орлого	0.0	5,332.8	5,332.8

Эх сурвалж: Дорнод аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх нийт орлогыг 82.2 хувь буюу 48,743.6 сая төгрөгийн татварын орлого, 17.7 хувь буюу 10,476.2 сая төгрөгийн татварын бус орлого байна.

Сангийн яамны хянасан дүнг нэмэгдүүлэн баталсан нь Сангийн яам зарим нэр төрлийн орлогыг хянадаггүй, төсвийн жилийн дундуур эрх зүйн актад өөрчлөлт орсон зэргээс шалтгаалсан байна.

Үүнд:

- Сангийн яам дараах орлогыг хянадаггүйтэй холбоотой:
 - Хөрөнгийн орлогыг нэмэгдүүлсэн нь малын тоо толгойд ногдуулах албан татварыг сумын ИТХ-ын шийдвэрээр зохицуулагддаг.
 - Бусад татварын нэмэгдүүлсэн нь газрын дуудлага худалдааны орлогыг орон нутгийн түвшинд ИТХ-аар шийдвэрлэгддэг.
 - Нийтлэг татварын бус орлого нэмэгдсэн нь ганц сумын түвшинд буюу ажлын байрны нөхөн төлбөрийн орлогыг Дашбалбар сум баталсан.
- Төсвийн жилийн дундуур өөрчлөлт орсон эрх зүйн акттай холбоотой:
 - Засгийн газрын тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн.
 - Хэрлэн сумын ИТХ Төсвийн жилийн дундуур хогны хураамжийн төлбөрийг нэмэгдүүлэн баталсан
 - Газрын төлбөрийн өмнөх оны авлагын дүн нэмэгдүүлэн баталсан.

1.2. Аймгийн татварын нийт орлого 7.7 хувиар буюу 3,723.0 сая төгрөгөөр давж биелсэн ч зарим нэр төрлийн орлого 2,943.8 сая төгрөгөөр тасарсан байна.

Нийт татварын орлого 3,723.0 сая төгрөг буюу 7.7 хувиар давж биелсэн байна.

Нийт татварын орлого давж биелсэн хэдий ч аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 11.4 хувиар, галт зэвсгийн албан татвар 5.0 хувиар, малын тоо толгойн албан татвар 4.5 хувиар, хог хаягдлын үйлчилгээний хураамж 50.9 хувиар, газрын төлбөр 29.8 хувиар буюу нийт 2,943.8 сая төгрөгөөр тасарсан байна.

Татварын орлого тасрахад доорх хүчин зүйл нөлөөлсөн байна. Үүнд:

1. Аж ахуйн нэгжүүд нь орлогын албан татвар оны эцэст төвлөрүүлсэн ч дахин хуваарилалтыг холбогдох журмын дагуу дараа сард хийдгээс шалтгаалан 1,371.2 сая төгрөгөөр,
2. Галт зэвсгийн албан татвар 2.1 сая төгрөгөөр,
3. Малын тоо толгойн албан татвар 83.6 сая төгрөгөөр,
4. Гэр хорооллын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого хураах гэрээг “ДБЭХС” ТӨХК-тай 2023 онд шинэчлэн байгуулаагүйгээс бүрэн төвлөрүүлээгүй, мөн 2023 оны 3 улиралд хог хаягдлын үйлчилгээний хураамжийн тариф шинэчлэн баталсан зэргээс шалтгаалж хог хаягдлын үйлчилгээний хураамж 524.1 сая төгрөгөөр,
5. Дорнод аймгийн ИТХ-ын тогтоолоор “Газрын төлбөрийн бүсийн зааг, итгэлцүүрийн хувь, төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн баталсантай холбоотойгоор цэргийн ангиуд, иргэний нисэхийн газарт өндөр хэмжээний ногдол үүссэн байна. Тухайн байгууллагуудын төлөх газрын төлбөрийг тухайн оны төсөвт батлаагүйгээс 962.8 сая төгрөгөөр.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.2.2-д “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”; 41.2-д “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ” 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Аудитын шийдвэр: Татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлэн ажиллах зөвлөмж өгөх.

Хүснэгт 2. Төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Татварын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	12,000.0	10,628.8	(1,371.2)	88.6
Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	400.0	558.6	158.6	139.7
Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого /суутган-1/	21,276.6	23,332.0	2,055.4	109.7
Галт зэвсгийн албан татвар	42.0	39.9	(2.1)	95.0
Хувь хүний орлогын албан татвар	847.5	928.5	81.0	109.6
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,037.8)	(1,037.1)	0.7	99.9
Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар	100.2	133.5	33.4	133.3
Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	1,023.5	1,302.0	278.5	127.2
Улсын тэмдэгтийн хураамж	445.9	1,551.1	1,105.3	347.9
Хүү торгууль	1,666.9	1,767.9	101.0	106.1
Бусад орлого	516.6	519.3	2.8	100.5
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	3,500.9	5,953.9	2,453.1	170.1
Түгээмэл тархацтай АМНАТ	60.0	62.7	2.7	104.5
Ойн нөөцийн төлбөр	15.0	16.4	1.4	109.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,030.5	506.4	(524.1)	49.1
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	1,654.8	2,047.7	392.8	123.7
Газрын төлбөр	3,233.0	2,270.2	(962.8)	70.2
Малын тоо толгойн албан татвар	1,847.8	1,764.2	(83.6)	95.5
Нийт дүн	48,623.2	52,346.2	3,723.0	107.7

Эх сурвалж: Дорнод аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дашбалбар, Матад, Хөлөнбуйр, Чулуунхороот сумд өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэлгүй малын тоо толгойн албан татварыг 305.6 сая төгрөгөөр дутуу тооцож төлөвлөсөн байна. Үүнд:

1. Хөлөнбуйр сум 22.1 сая төгрөгөөр,
2. Матад сум 135.9 сая төгрөгөөр,
3. Дашбалбар сум 127.6 сая төгрөгөөр.
4. Чулуунхороот сум 20.0 сая төгрөгөөр

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д “Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг тодорхойлно” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Аудитын шийдвэр: Сумдын төсвийн орлогын төлөвлөлтөд арга зүйн зөвлөгөө өгч, хяналтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөх.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох 1,118.9 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу олгосон байна.

БҮЛЭГ 2. ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамны хянасан зардлын хязгаараас нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Аймгийн 2023 оны төсвийн төслийн суурь зарлагыг Сангийн яамнаас баталсан дээд хязгаараас 6,319.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 19,180.0 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн 2023 оны зарлагыг Сангийн яамны баталсан суурь хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Зардлыг суурь хязгаартай харьцуулсан харьцуулалт. /сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	Сангийн яамны хянасан төсөв	2023 оны батлагдсан төсөв	Зөрүү
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА	12,860.2	19,180.0	6,319.8
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	284.6	743.8	459.2
Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1,362.4	1,270.3	(92.1)
Аймгийн Засаг даргын Тамгын газар	1,712.9	2,991.4	1,278.5
Сумын Засаг даргын Тамгын газар	5,569.7	8,529.8	2,960.1
Санхүүгийн хяналт, аудитын алба	183.5	366.1	182.6
Орон нутгийн өмчийн газар	181.0	291.3	110.3
Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	1,984.1	2,442.4	458.3
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	1,457.5	1,829.4	371.9
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	526.6	613.0	86.4
Ойн анги /Халхгол, Баян-Уул сум/	101.5	220.6	119.1
Хот тохижуулах газар	1,041.8	1,520.9	479.1
Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ	1,041.8	1,520.9	479.1
Аймгийн Засаг даргын нөөцийн сан	250.0	512.8	262.8
Аймгийн халамжийн сан	188.6	290.6	102.0

Эх сурвалж: Дорнод аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Сангийн яамны хянасан хязгаараас зардлыг хэтрүүлэн төлөвлөхөд дараах шалтгаан нөлөөлсөн байна. Үүнд:

1. Сангийн яамны хянасан орон тооны хязгаараас аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 5, Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 4, аймгийн

Засаг даргын Тамгын газар 11, сумдын Засаг даргын Тамгын газар 14, Санхүүгийн хяналт, аудитын алба 5, Орон нутгийн өмчийн газар 3 орон тоогоор хэтрүүлэн төлөвлөсөн.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ойн анги /Халхгол, Баян-Уул сум/, Хот тохижуулах газар, Аймгийн Засаг даргын нөөцийн сан, Аймгийн халамжийн сангийн зардлыг нэмж төсөвлөхөд байгалийн давагдашгүй хүчин зүйл (түймэр) нөлөөлсөн.

2.2. Төсвийн нийт зарлага 77,330.5 сая төгрөг байна.

Аймгийн төсвийн нийт зарлага 87.2 хувь буюу 77,330.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Нийт зардлын 51.2 хувийг урсгал зардал, 47.4 хувийг хөрөнгийн зардал, 1.4 хувийг эргэж төлөгдөх төлбөр эзэлж байна.

Хүснэгт 4. Зардлын төлөвлөлт, гүйцэтгэл /сая.төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	88,613.1	77,330.5
УРСГАЛ ЗАРДАЛ	42,643.1	39,637.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	44,171.4	36,596.2
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,798.6	1,096.7

Эх сурвалж: Дорнод аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар Дорнод аймгийн улсын төсөвт шилжүүлэх орлогын хэмжээг 3,050.8 сая төгрөгөөр баталсныг бүрэн төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын зардлыг 3,465.8 сая төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтыг 5,685.8 сая төгрөгөөр, хөдөө аж ахуйг хөгжүүлэх санг 203.1 сая төгрөгөөр, байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх зардлыг 538.3 сая төгрөгөөр, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг 653.1 сая төгрөгөөр болон бусад урсгал зардлыг гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн байна.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарахгүй улсын төсвийн Төрийн тусгай албан хаагчд (Тагнуулын газар)-ын орон сууц худалдан авахад орон нутгийн төсвөөс 420.0 сая төгрөгийг төлөвлөн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг", 6 дугаар зүйлийн 6.6.6-д "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын бус төсөл, арга хэмжээний санхүүжилтээр Хэрлэн сумын 11 багийн 144 хэсгийн ахлагч нарын урамшуулалд 99.4 сая төгрөг, Хөдөө аж ахуйн сангийн хөрөнгөөр 673.7 сая төгрөгөөр 400 ширхэг хүлэмжийг иргэдэд олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх;" 13.3-д "хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ"-г орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Аудитын шийдвэр: Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй, хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй хөрөнгийг төсөвт тусгахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2.3. Дорнод аймгийн 2023 оны төсөвт 3 удаа өөрчлөлт хийсэн байна

Дорнод аймгийн 2023 оны төсвийг аймгийн ИТХ-ын 2022 оны 13/11 дүгээр тогтоолоор батлан, 2023 оны 15/02, 17/02, 19/09 дугаар тогтоолуудаар 3 удаа өөрчлөлт хийсэн байна.

Дээрх төсөвт хийсэн 3 удаагийн өөрчлөлтөөр Төрийн аудитын байгууллагаас 2023 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтээр хянагдаагүй 6,557.4 сая төгрөгийн 70 төсөл, арга хэмжээг нэмж, 694.2 сая төгрөгийн 15 арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7-д “Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн тохиолдолд түүнийг тухайн жилийн төсвийн тодотголд тусган өөрчилнө” 34 дүгээр зүйлийн 34.2.3-д “энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Хүснэгт 5. Төсөл, арга хэмжээнд орсон өөрчлөлт

д/д	Үзүүлэлт	ТАБ-аар хянагдаагүй		Төсөвт өртгийг нэмэгдүүлсэн		Нийт өөрчлөлтийн	
		тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн
1	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	37	4,079.8	2	85.9	39	4,165.7
2	Орон нутгийн хөгжлийн сан	22	2,211.2	5	406.2	27	2,617.4
3	Автозамын сан	3	143.4	0	-	3	143.4
4	Хөрөнгө оруулалт бус төсөл, арга хэмжээ	8	123.0	8	202.1	16	325.1
Нийт дүн		70	6,557.4	15	694.2	85	7,251.6

Эх сурвалж: Дорнод аймгийн 2023 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын шийдвэр: Төрийн аудитын байгууллагаар хянагдаагүй төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2.4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэлт санхүүжилтийн дансны нийт зардал 6,430.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас хуваарилсан 6,142.1 сая төгрөгийн, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн 16.8 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 271.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлснээс 6,284.3 сая төгрөгийн зарцуулалт хийж, 145.8 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 6. Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэл.

Тайлангийн үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,430.1
УРСГАЛ ЗАРДАЛ	6,021.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,386.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	140.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10.2
Хангамж, бараа материалын зардал	116.7
Нормативт зардал	2.0
Эд хогшил, урсгал засварын зардал	22.1
Томилолт, зочны зардал	20.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	940.2

Бараа үйлчилгээний бусад зардал	4,132.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	635.1
Бусад урсгал шилжүүлэг	489.3
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	145.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	408.6
Дотоод эх үүсвэрээр	408.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,430.1
Нэмэлт санхүүжилтийн орлого	6,430.1

Эх сурвалж: Дорнод аймгийн 2023 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн бараа үйлчилгээний бусад зардлын 53.2 хувь буюу 2,200.0 сая төгрөг нь шүүхийн шийдвэрийн дагуу хэлмэгдэгсэд болон тэдний ар гэрт олгосон нөхөн олговор эзэлж байна.

БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨЛӨВЛӨСӨН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮР ДҮН.

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 87.2 хувийн гүйцэтгэлтэй байна

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт хамрагдах 21 төсөл арга хэмжээ батлагдсанаас орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны 1 хөтөлбөрт хамаарах 3 арга хэмжээ, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт хамаарах орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлэх 18 арга хэмжээнд 77,330.5 сая төгрөгийг зарцуулан хэрэгжилт 87.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хэрэгжээгүй төсөл, арга хэмжээг дурдвал дараах байдалтай байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 117.6 сая төгрөгийн 2 ажил хийгдээгүй байна.
 - Гүний худгийн цэвэршүүлэх тоног төхөөрөмж худалдан авах 110.5 сая төгрөг,
 - Төрийн байгууллагын албан хэрэгцээнд компьютер тоног төхөөрөмж авах 228.1 сая төгрөг
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 1,899.2 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
 - Хөгжлийн төлөвлөгөө батлуулах (Гурванзагал сум) 18.0 сая төгрөг
 - Төв болон туслах авто замын ус зайлуулах сувгийг шинэчлэх (Хэрлэн сум) 43.0 сая төгрөг
 - Жимсний мод, хүнсний ногоо тариалахыг дэмжиж усан хангамжийг нэмэгдүүлэх, "Ногоон гудамж" төсөл хэрэгжүүлэх 250.0 сая төгрөг
 - Ялалт гүүрний 2 талд авто зам тавих ажлыг үргэлжлүүлэх 120.0 сая төгрөг
 - Хог хаягдал цэвэрлэх булшлах /Хэрлэн/ 300.0 сая төгрөг
 - Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамжны авто замаас Мянгат хороолол чиглэлийн хатуу хучилттай авто зам (Хэрлэн сум 7 дугаар баг) 289.0 сая төгрөг
 - Автозамын ус зайлуулах байгууламж (Хэрлэн сум) 195.0 сая төгрөг
 - Соёлын төвд "Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих" танхимд тоног төхөөрөмж (Матад сум) 50.0 сая төгрөг
 - Чойбалсан хотын усан хангамжийн шугам хоолойд усны чанар сайжруулах тоног төхөөрөмж суурилуулах (Хэрлэн сум) 634.2 сая төгрөг

Энэ нь тайлант жилийн хугацааны татварын орлого бүрэн төвлөрөөгүйгээс шалтгаалсан байна.

Аудитын шийдвэр: Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрэх үр дүнг ханган ажиллах зөвлөмж өгөх.

БҮЛЭГ 4. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ 86.8 ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ БАЙНА.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 86.8 хувийн хэрэгжилттэй байна. Үүнд:

1. *Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд Төрийн аудитын байгууллагаас өгсөн санал, дүгнэлт, төсөл арга хэмжээний зураг төсөө хийгдсэн, тооцоо бодитой үнэн зөв, тухайн төслийн санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцээтэй эсэх, бараа материалын үнийн өсөлт, тооцоо судалгаанд үндэслэн батлах-60 хувийн хэрэгжилттэй.*
2. *Орон нутгийн төсвийн орлогыг татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдал, эрсдэлийг тооцон, тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөн Сангийн яамаар хянуулан батлуулах-100 хувийн хэрэгжилттэй.*
3. *Батлагдсан хөтөлбөр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, хүрэх үр дүнг хангаж ажиллах-87.2 хувийн хэрэгжилттэй.*
4. *Улсын төсөвт шилжүүлэх болон аймгийн төсвийн орлогын биелэлтийг ханган ажиллах-100 хувийн хэрэгжилттэй.*

Аймгийн 2023 оны төсвийн төсөлд хийсэн аудитын шийдвэрийн биелэлт 67.6 хувийн хэрэгжилттэй байна. Үүнд:

1. *Орлого нэмэгдүүлэх 720.1 сая санал хүргүүлснээс 692.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 96.2 хувийн хэрэгжилттэй.*
2. *Зарлага бууруулах 3,348.4 сая төгрөгийн саналаас 220.0 сая төгрөгөөр бууруулан 6.6 хувийн хэрэгжилттэй.*
3. *Төсвийн үр ашгийг дээшлүүлэх 2,286.6 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээний биелэлт 100 хувийн хэрэгжилттэй.*

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Татварын зарим нэр төрлийн орлого 2,943.8 сая төгрөгөөр тасарсан байна.
2. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох 1,118.9 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу олгосон байна.
3. Төсвийн нийт зарлага 87.2 хувийн гүйцэтгэлтэй байна.
4. Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй хөрөнгөнд 773.1 сая төгрөгийг зарцуулсан.
5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарахгүй улсын төсвийн байгууллагууд орон нутгийн төсвөөс нийт 420.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөн зарцуулсан.
6. Төрийн аудитын байгууллагаас 2023 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтээр хянагдаагүй 6,557.4 сая төгрөгийн 70 төсөл, арга хэмжээг нэмж, 694.2 сая төгрөгийн 15 арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэн баталсан байна.
7. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 87.2 хувийн гүйцэтгэлтэй байна.
8. Өмнөх аудитын шийдвэрийн биелэлт 86.8 хувийн хэрэгжилттэй байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4202, факс: 7058-4584
Цахим шуудан: azdtg@dornod.gov.mn
Цахим хуудас: Dornod.gov.mn

Д.Норинзориг
Энэ тусгагдсан зарим дүгнэлтийн талаарх тайлбарыг асуудлын бүртгэлээр хүргүүлсэн болно.
2024.04.25

2024.04.25 № 1/1011
танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

Аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Нэгдсэн тайлангийн төсөлд тусгагдсан зарим дүгнэлтийн талаарх тайлбарыг асуудлын бүртгэлээр хүргүүлсэн болно.

ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН



212407132

Холбогдох байгууллагын ирүүлсэн тайлбарт дахин горим хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Тайлангийн төслийн 2.2-д тусгагдсан 170.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 5 төсөл, арга хэмжээ нь тусгайлсан чиг үүргийн байгууллагын хуулиар зохицуулагдаж байгаа тул зөрчлөөс хасаж тайланд тусгав.
2. Тайлангийн төслийн 1.2-д тусгагдсан татварын орлого тасарсан нь Аж ахуйн нэгжүүд нь орлогын албан татвар оны эцэст төвлөрүүлсэн ч дахин хуваарилалтыг холбогдох журмын дагуу дараа сард хийдгээс шалтгаалсан, 3.1-д тусгагдсан ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүн бүрэн хангагдаагүй нь татварын орлого тайлант хугацаанд төвлөрөөгүйгээс шалтгаалсан байгаа тул зөвлөмж болгон шийдвэрлэв.

САНАЛ:

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дараах асуудлыг тусгуулах саналтай байна. Үүнд

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дахин хуваарилалтыг төсвийн жилд багтаан орон нутагт шилжүүлж байх талаар Сангийн яаманд зөвлөмж хүргүүлэх.
2. Төсвийн хязгаарыг хянахдаа төсөвт байгууллагуудын орон тоог бодитой тооцох талаар Сангийн яаманд зөвлөмж хүргүүлэх.

Аудитаар нийт 11,388.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 8,444.7 сая төгрөгийн 2 албан шаардлага, 2,943.8 сая төгрөгийн 3 зөвлөмж, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгуулах 2 санал өгч ажиллалаа.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд

1. Татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлэн ажиллах.
2. Сумдын төсвийн орлогын төлөвлөлтөд арга зүйн зөвлөгөө өгч, хяналтыг хэрэгжүүлэн ажиллах.
3. Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй, хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй хөрөнгийг төсөвт тусгахгүй байх.
4. Төрийн аудитын байгууллагаар хянагдаагүй төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх.
5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрэх үр дүнг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу ирүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/04

Чойбалсан хот

Г Тайлан баталгаажуулах тухай Г


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорнод аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга М.Энхтөр, Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Д.Нармандах-д даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010141



Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр, албан тушаал	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн акт, албан шаардлагын утга	Мөнгөн дүн /сая.төг/
1	Аймгийн Засаг дарга	ДОА-2024/01/НА-СТА-ТЕЗ	Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй, хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй хөрөнгийг төсөвт тусгахгүй байх.	1,193.1
2			Төрийн аудитын байгууллагаар хянагдаагүй төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх.	7,251.6
Нийт дүн				8,444.7

---oOo---